

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 11 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Цахим хөгжлийн багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2022 оны 10 дугаар сарын 01-ээс 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллав.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрөл, цахим үйлчилгээний чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд 1064 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 725 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 339 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ. (Хүснэгт 1)

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 348 гадаадын иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз хилийн боомтод олгосон. Мөн 3 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл олголоо. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Визийн зөвшөөрөл		Виз	Оршин суух зөвшөөрөл			Түр ирэгч	
Хилийн чанадад	Хилийн боомтод		олгосон	сунгасан	хэлбэр, төрөл өөрчилсөн	хаягийн бүртгэл	байх хугацаа сунгалт
725	339	348	1419	629	0	2483	2231
1064							


1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 1419 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 629 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 769 иргэний бүртгэлд хасалт хийсэн. (Хүснэгт 1)

Гадаадын иргэнийг уригч 36 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 90 гадаадын иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 2483 гадаадын иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэсэн. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй

зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 2231 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (Хүснэгт 1)

График 1



Дээрх тоон үзүүлэлтийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 58.9 хувь, виз олголт 25.3 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 52.0 хувиар тус тус өсөж, оршин суух зөвшөөрлийн сунгалт 11.6 хувиар буурчээ.

“Монгол Улсад оршин суух үнэмлэх” 1602 ширхэг шинээр хэвлэж, 408 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 34 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн 139 гадаадын иргэний хүсэлтийг байгууллагын даргын 3 удаагийн тушаалаар шийдвэрлэж, 7 иргэнд регистрийн дугаар олгосон.

1.1.3. Цахим үйлчилгээ, программ хангамж:

Энэ сард нийт 626 аж ахуйн нэгж, байгууллагын 1519 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.

Визийн мэдээллийн нэгдсэн сан “evisa.mn” системээр нийт 27 улсын 378 иргэнд цахим виз олгож, 3 улсын 23 гадаадын иргэний визийн хүсэлтэд татгалзсан.

Eimmigration.mn системд ирүүлсэн хүсэлтийг PDF хэлбэрээр татаж авах болон системийн 48 цагийн бүртгэлийн хэсэгт холбогдох утасны дугаар харуулах тохиргоог оруулж, төрийн “Цахим шуудангийн систем”-ийн шинэчлэлтэй холбогдуулан SMTP тохиргоог шинэчиллээ.

Eimmigration систем дэх оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэний мэдээллийг “Оршин суух үнэмлэх хэвлэх программ” (RCP)-д дамжуулах сервис (API) шинээр хөгжүүлэв.

Гадаадын иргэний бүртгэлийн дугаар олгох (RNSF) системийн сервисийг Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газартай холбож мэдээлэл харилцан солилцож эхэлсэн.

Оршин суух үнэмлэх хэвлэх программ (RCP)-д зориулж RNSF системээс Register болон бусад шаардлагатай мэдээллийг дамжуулах сервис үүсгэлээ.

1.1.4. Зөвлөгөө, мэдээлэл:

Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 3686 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

1800-1882 утас	Биечлэн	Фэйсбүүк хуудас чат	Автомат хариулагч	Имэйл	Нийт
2426	1078	22	138	22	3686

Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд биечлэн 64 иргэнд, утсаар 57 иргэнд зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ үзүүлсэн.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Иргэний харьяалал:

Харьяатын асуудлаар нийт 17 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 9 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа. (Хүснэгт 4)

Хүснэгт 3

Хугацаа	Монгол Улсын харьяат болсон	Иргэний харьяаллыг сэргээн тогтоосон	Монгол Улсын харьяатаас гарсан	Хоёрдмол харьяалалтай иргэнийг бүртгэсэн
10 дугаар сар	1	1	-	29
2022 он (өссөн дүнгээр)	2	1	-	414

Түүнчлэн 6 иргэн, 5 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 20 иргэний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн. (Хүснэгт 4)

Хүснэгт 4

Иргэний харьяаллын талаарх сарын мэдээ						
д/	Харьяалах улс	Хүлээн авсан хүсэлт	Түдгэлзүүлж буцаасан хүсэлт	Саналд илгээсэн	ЗГХЭГ-т хүргүүлсэн	ЕТГ-т хүргүүлсэн
Монгол Улсын харьяат болох						
1	-	-	-	-	-	-
	нийт	-	-	-	-	-
Монгол Улсын харьяатаас гарах						
1	Монгол Улс	17	-	9	6	20
	нийт	17	-	9	6	20
Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох						
1	Харьяалалгүй хүн	-	-	-	5	-
	нийт	-	-	-	5	-

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 206 дугаар зарлигаар Оросын Холбооны Улсын 1 иргэн Монгол Улсын харьяат болсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 207 дугаар зарлигаар харьяалалгүй 1 хүний иргэний харьяаллыг сэргээн тогтоожээ.

Тус байгууллагын Баруун бүс дэх газар “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан”-д Бүгд Найрамдах Казахстан Улсын хоёрдмол харьяалал үүсгэсэн 910 иргэний мэдээллээс Ховд аймгийн регистрийн дугаартай 192 иргэний мэдээлэлд шүүлт хийж, Ховд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Халамж үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн 7997 иргэний нэрстэй тулгаж ажиллав.

“Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 52 улсын 4296 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна.

Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 29 иргэнийг “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д шинээр бүртгэсэн. (Хүснэгт 3)

1.2.2. Хүүхэд үрчлэлт:

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын иргэн, гэр бүлд үрчлүүлсэн 2 хүүхдийн тайланг хүлээн авч, “Гадаад улсын иргэнд үрчлүүлсэн Монгол Улсын хүүхдийн мэдээллийн сан”-д бүртгэсэн.

10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 274 Монгол хүүхдийг үрчлүүлээд байна.

1.2.3. Олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн 78 газар бүртгэлтэй байна.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Төлөвлөгөөт 1 удаагийн хяналт шалгалтаар 17 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгахад зөрчил илрээгүй байна.

Төлөвлөгөөт бус 33 удаагийн хяналт шалгалтад 51 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан, 173 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгаж, 4 зөрчлийг илрүүлэн 3 зөрчилд албан шаардлага өгч, 1 зөрчилд торгох шийтгэл оногдуулж, Монгол Улсаас албадан гаргахаар шийдвэрлэсэн.

Хүснэгт 5

Зөрчлийн мэдээ (тухайн сараар)							
Хувь хүн		Уригч байгууллага			Уригч хувь хүн		
Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
14	3,300,000	1	1	2,110,000	-	-	-
нийт 5,410,000 төгрөг							

Үүнээс гадаадын иргэн		
Хуулийн үндэслэл	Шалтгаан	Гадаадын иргэний тоо
Зөрчлийн тухай хууль 16.2-1.2	нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн	11
Зөрчлийн тухай хууль 16.2-1.4	нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн	1
Зөрчлийн тухай хууль 16.2-1.5	ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан	1
Зөрчлийн тухай хууль 16.2-3.3	визийн хугацааг хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно	1
бүгд		14

Тайлант хугацаанд 5 улсын 14 гадаадын иргэн, 1 уригч байгууллага (1 иргэн)-д холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн дагуу нийт 5,410,000 төгрөг (Таван сая дөрвөн зуун арван мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (Хүснэгт 5, 6, 7)


Хүснэгт 6

Торгуулсан гадаадын иргэн (тухайн сараар)							
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл				Бүгд	Торгуулийн дүн
		16.2-1.2	16.2-1.4	16.2-1.5	16.2-3.3		
1	Беларусь	1				1	100,000
2	Казахстан				1	1	2,000,000
3	Норвеги	1				1	100,000
4	Өмнөд Солонгос	2				2	200,000
5	Хятад	7	1	1		9	900,000
Нийт		11	1	1	1	14	3,300,000

Хүснэгт 7

Торгуулсан уригч байгууллага (тухайн сараар)					
№	Харьяалах улс	Зүйлчлэл	Уригч иргэний тоо	Бүгд	Торгуулийн дүн
		16.2-4.2			
1	Хятад	1	1	1	2,110,000
Нийт		1	1	1	2,110,000

График 2



Холбогдох хугацааны тоон үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 2.8 дахин, зөрчил гаргасан уригч иргэн 2 дахин, албадан гаргасан гадаадын иргэн 60.0 хувь, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 55.6 хувь, саатуулсан гадаадын иргэн 33.3 хувиар тус тус өсөж, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 14.3 хувиар буурсан байна.

Гадаадын иргэний виз, бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд хугацаа хэтрүүлсэн 216 улсын 153495 иргэн, харьяалалгүй 877 хүн нийт 154372 гадаадын иргэний мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулан тулгалт хийж, тус улсаас гарсан, хугацаа хэтрүүлсэн мэдээллийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцууллаа.

1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.2 дахь заалтыг үндэслэн 2 улсын 2 иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар түр түдгэлзүүлж, мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалтыг үндэслэн тус улсаас гарахыг түдгэлзүүлсэн 1 улсын 1 иргэний хилээр нэвтрэх эрхийг 1 удаагийн тушаалаар сэргээсэн байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.7, 37.1.9, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 4 улсын 9 иргэнийг байгууллагын даргын 4 удаагийн тушаалаар албадан гаргахаар шийдвэрлэлээ. (Хүснэгт 9)

Хүснэгт 9

Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээ (тухайн сараар)						
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл				Нийт
		37.1.2	37.1.7	37.1.9	37.1.12	
1	Америк			1		1
2	Филиппин				1	1
3	Хятад	1	5			6
4	Швейцарь			1		1
Бүгд		1	5	2	1	9

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7.4 дэх хэсэгт заасныг үндэслэн 1 улсын 1 иргэнийг 1 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргасан шийдвэрийг хугацаанаас өмнө цуцалсан.

Тайлант хугацаанд виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн үндэслэлээр нийт 8 улсын 470 иргэнийг Монгол Улсын хилээр оруулахгүй буцаасан. Үүнээс:

- Хойд бүс дэх газар виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 8 улсын 470 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаажээ.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэр, холбогдох төлөвлөгөө, тайлан:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний байгууллагад холбогдох арга хэмжээний хэрэгжилтийн 10 дугаар сарын тайланг үнэлгээний хамт “Төрийн мэдээллийн сүлжээ” (mojha.unelgee.gov.mn) системд байршуулав. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 100 хувь, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 65.0 хувь, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт 82.5 хувьтай байгууллагын хэмжээнд үнэлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын байгууллагын чиг үүрэгт холбогдох заалтын хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хэлбэрээр тайлагналаа.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамжид тусгасан ажлын гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний мөрөөр хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр ирүүлсэн үүргийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад, Засгийн газрын 2022 оны “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолын дагуу төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судлан, холбогдох саналыг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдад тус тус хүргүүлсэн.

Цагаан-дэл уул боомтыг нээж ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг судалж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх “Дэд ажлын хэсэг”-ийн ээлжит хуралдаанд оролцож холбогдох мэдээлэл солилцлоо.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц, сургалт:

Төрийн захиргааны гүйцэтгэх 2 албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, тусгай шалгалтын hh-admin.csc.gov.mn цахим системд сонгон шалгаруулалтын захиалгыг баталгаажуулан нээлттэй зарлуулаа.

Хилийн боомт, орон нутагт ажилласан хяналтын улсын байцаагчид олгох 5 жил тутмын урамшууллыг байгууллагын даргын 10 дугаар сарын 26-ны өдрийн Б/289 дүгээр тушаалаар 1 албан хаагчид олгохоор шийдвэрлүүлэв.

Татварын ерөнхий газар, Нийслэлийн татварын газартай хамтран “Аж ахуйн нэгж, байгууллагад татвар ногдуулах, тайлагнах, тэдгээртэй холбогдох харилцаа” сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 28 албан хаагчийг оролцуулав.

2.1.3. Олон нийт, хэвлэл мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудсанд үйл ажиллагаатай холбоотой 12, цахим сүлжээнд 16 мэдээ, мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор нийт 50 мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчиллаа. Байгууллагын цахим хуудас (фейсбүүк, твийтэр), eimmigration систем дэх мэдээллийг тухай бүр баяжуулж, байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой мэдээ мэдээллийг тогтмол байршуулж байна.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

2.2.1. Хууль, эрх зүй:

“Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж ажиллав.

Хүний нөөцийн чиглэлээр 15, Виз, зөвшөөрлийн чиглэлээр 2, Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр 2, Санхүүгийн чиглэлээр 2 бусад чиглэлээр 1 нийт 22 тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг тус тус хянаж, холбогдох саналаа тусгалаа.

Байгууллагын 6 албан хаагчид холбогдох “Суралцагчтай байгуулах гэрээ”, Худалдаа хөгжлийн банкттай байгуулах “Хамтран ажиллах гэрээ”, Гадаадын иргэн, харьяатын газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын хооронд байгуулах “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн төслүүдийг тус тус хянаж, холбогдох саналаа тусгасан.

2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Байгууллагын дарга Австралийн Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга, Америкийн Нэгдсэн Улсын Хил, гаалийн хяналтын албаны ажилтан болон Туркийн хамтын ажиллагааны зохицуулах агентлаг (ТИКА)-ийн ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчдийг тус тус хүлээн авч уулзлаа.

Түүнчлэн Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА)-ийн дарга, дэд дарга нарыг хүлээн авч, уулзалтаар 2023-2026 онд хэрэгжүүлэх боловсон хүчний чадавхыг сайжруулах төслийн талаар санал солилцов.

Бүгд Найрамдах Турк Улсын Цагдаагийн ерөнхий газрын Хууль бус цагаачлал, хилийн хяналтын газартай хамтын ажиллагааны хүрээнд байгуулах “Санамж бичиг”-ийн төсөлд санал авах тухай хүсэлт болон Монгол Улс, Япон Улсын Цагаачлалын байгууллага хоорондын хамтын ажиллагааны баримт бичигт тусгах саналыг Гадаад харилцааны яаманд, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний цагаачлалын удирдах газартай хамтын ажиллагааны хүрээнд байгуулах “Санамж бичиг”-ийн төсөлд санал авах тухай албан хүсэлтийг Монгол Улсаас тус улсад суугаа Элчин сайдын яаманд тус тус хүргүүлж ажилласан.

10 дугаар сарын 28-аас 30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, цахим визийн мэдээлэл болон бусад үйлчилгээ, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан, гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөлд зөвлөгөө мэдээлэл хүргэж оролцлоо.

2.3. Дотоод хяналт:

“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээ, судалгааны тайлантай холбогдуулан холбогдох саналыг 10 дугаар сарын 07-ны өдрийн 02/1747 дугаар албан бичгээр, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 10 дугаар сарын 24-ний өдрийн 02/1848

дугаар албан бичгээр тус тус Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

2019 оны 25 хадгаламжийн нэгжийн 6250 хуудас баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн санг баяжууллаа.

2009-2012 оны түр хадгалах 559 хадгаламжийн нэгжийг түүвэрлэн устгах хэргийн жагсаалт үйлдэн “Баримт нягтлан шалгах комисс”-ын 12 дугаар сарын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

Байгууллагад ирүүлсэн нийт 199 албан бичиг (хариутай 118)-ийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд бүртгэлээр шилжүүлэн, нийт 190 албан бичгийг гадагш илгээсэн ба 13 албан бичиг шийдвэрлэх хугацаандаа хянагдаж байна.

ERP, EDOC программыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхтэй холбогдуулан тус программд албан бичиг, тушаал, тодорхойлолт зэрэг хэвлэмэл хуудсыг байршуулж, баримт бичиг боловсруулах ажлыг хэрэгжүүлж эхэллээ.

2.4.2. Өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, албан хаагчаас 85 өргөдөл, 4 гомдол ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүлээн авлаа.

- Төв байгууллагад 40 өргөдөл, 4 гомдол (иргэнээс 21 өргөдөл, 4 гомдол, албан хаагчаас 19 өргөдөл);
- Боомт, орон нутаг дахь нэгжид 45 өргөдөл (иргэнээс 21 өргөдөл, албан хаагчаас 24 өргөдөл);

Үүнээс: 76 өргөдөл, 3 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн 9 өргөдөл, 1 гомдол шийдвэрлэх шатанд, хугацаа сунгасан 3 өргөдөл 1 гомдол бүртгэлтэй байна.

2.5. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

2.5.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

Оны эхнээс 10 дугаар сарын байдлаар (өссөн дүнгээр) 7,389.7 сая төгрөгийн санхүүжилт авч 6,161.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлж ажиллалаа.

Шилэн дансны тухай хуулийн дагуу (өссөн дүнгээр) төсөв санхүүгийн 304 мэдээ, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 256 мэдээ, бусад 408 мэдээ буюу нийт 968 мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд www.shilendans.gov.mn сайтад байршууллаа.

2.5.2. Орлого төвлөрүүлэлт:

Оны эхнээс 10 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон (өссөн дүнгээр) Голомт банканд байрших 1320000052 тоот төгрөгийн дансанд 1,136.3 сая төгрөг, 1305124929 тоот валютын дансанд 205,928.54 ам.доллар буюу 639.8 сая төгрөг, орон нутаг дахь нэгжүүд нийт 1,105.5 сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг харьяа орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлээд байна.

Мөн дээрх хугацаанд (өссөн дүнгээр) хүү торгуулийн 40.5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Улсын төсвийн 100900012003 тоот харилцах дансанд визийн үйлчилгээний 5 ам.долларын 164.6 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

2.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

2.6.1. Хяналт-шинжилгээ:

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 10 дугаар сарын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Төрийн мэдээллийн сүлжээ (mojha.unelgee.gov.mn)-нд байршуулж баталгаажууллаа.

Гадаадын иргэний бүртгэл, хяналтын 09 дүгээр сарын статистик мэдээ, байгууллагын 09 дүгээр сарын үндсэн үйл ажиллагааны тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Хууль зүй, дотоод хэргийн яаманд, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын 2022 оны 3 дугаар улирлын танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд тус тус хүргүүлэв.

2.6.2. Аудит, нийцлийн чиглэлээр:

Байгууллагын даргын 10 дугаар сарын 03-ны өдрийн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар дотоод аудит хийх тухай” 01-10/06 дугаар удирдамжийн дагуу аудит хийж, үр дүн, тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн ажиллалаа.

ДАРГА

Н.УУГАНБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.МӨНХБААТАР

НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ГЭРЭЛТУЯА